



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Болдын УЯНГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-62. Факс: 32-70-16
E-mail: uyanga@parliament.mn
http://www.parliament.mn

2025.05.12 № 417-03/6068
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/1326 дугаар албан бичигтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсралтаар хүргүүлж байна.

"Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хүлээн авна уу.

Хавсралт²⁶ хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.УЯНГА

ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАНИЛЦУУЛГА

Олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4-т заасны дагуу цахим хэлбэрээр явуулахаар 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр d.parliament.mn цахим хуудсанд байршуулан ажилласан.

2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар тус хуулийн төсөлд 2 санал, дэмжлэг ирүүлсэн байна. Үүнд:

Д/д	Нэр	Ирүүлсэн санал	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	Иргэн н.Өнөболд	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын амралт долдугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15 өдрүүд. Хэрвээ 10-ны өдөр бүтэнсайн өдөр таарвал хойш нь гүйлгэж 18-нд шилжүүлж амраана гэж ойлгох уу?	Тус санал нь хуулийн төсөлд тусгасан агуулгатай бүрэн нийцэж байгаа саналыг хүлээн авсанд тооцохоор байна.
2	Иргэн н.Өнөболд	Энэ төсөл энд бүтэн сар боллоо. Нэг л заалт өөрчилнө. Дараагийн шат руу явах болоогүй юу?	Үндэсний Их баяр наадмын баярын өмнө уг хуулийн төслийг УИХ-ын хаврын Нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.